



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2020 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/119

Мандалговь

“Дархан-Үйлс” ХХК-тай гэрээ  
байгуулах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн А/69 дүгээр тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Бог мал угаах ванн шинээр барих ажил”-ын багц-1 (Дундговь, Адаацаг, Сайхан-Овоо, Эрдэнэдалай, Хулд сум) гүйцэтгэгчээр шалгарсан “Дархан-Үйлс” ХХК-тай 68,940,441 (жаран найман сая есөн зуун дөчин мянга дөрвөн зуун дөчин нэг) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан ажлын зураг, төсвийн дагуу “Бог мал угаах ванн шинээр барих ажил”-ын багц-1 (Дундговь, Адаацаг, Сайхан-Овоо, Эрдэнэдалай, Хулд сум) чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Дархан-Үйлс” ХХК-ийн гүйцэтгэх захирал (Б.Нямбаяр)-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Мал эмнэлэгийн дарга (Ш.Мөнхдүүрэн), Адаацаг сумын Засаг дарга (Ж.Батхөлөг), Сайхан-Овоо сумын Засаг дарга (Б.Түвшинбаатар), Эрдэнэдалай сумын Засаг дарга (С.Мөнхбаатар), Хулд сумын Засаг дарга (Ч.Зоригтбаатар) нарт ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (А.Ганбат) нарт үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ЭРДЭНЭСҮРЭН



482060493